



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл”  
бүхий зохицуулалттай этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын  
үйлчилгээний хөлсийг нэг удаа чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8 дугаар хавсралтад заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс болох Хорооны 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 156 дугаар тогтоолын хавсралтад заасан 100,000.0 /Нэг зуун мянган/ төгрөгөөс чөлөөлсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000130